

СОЛОНГОСЫН ХОЙГ ДАХЬ АНУ-ЫН ГАДААД БОДЛОГО: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

И.Энхболд¹

Товч агуулга:

Миний илтгэлийн эхлэл хэсэгт, АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамагийн засаг захиргаанаас сүүлийн 5 жилийн хугацаанд Солонгосын хойгийн талаар баримталсан бодлогыг хөндөн авч үзлээ. Ялангуяа Барак Обамагийн засаг захиргаанаас Умард Солонгосын талаар явуулж ирсэн “Хүлээцтэй байх стратеги”(Strategic patience) бодлогыг Умард Солонгост цөмийн зэвсгээ хөгжүүлэх боломж олгож байна гэж шүүмжлэх явдал АНУ-д газар авч байсан үед саяхан АНУ-д Ерөнхийлөгчийн сонгууль болж өндөрлөлөө.

Ингэснээр илтгэлийнхээ үндсэн хэсэгт, 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр АНУ-ын Ерөнхийлөгчийн тангарагаа өргөж үүрэг ажилдаа орсон Дональд Трампын Азийн орнууд руу явуулах бодлого, тэр дундаа Солонгосын хойгийн аюулгүй байдлын асуудлаар түүний дэвшүүлэн тавих шинэ стратеги, ашиг сонирхол нь ямар эерэг, сөрөг нөхцөл байдлыг авчирч болох талаар англи, герман, солонгос хэлээрх судалгааны баримт материалд дүн шинжилгээ хийх замаар урьдчилсан таамаглал дэвшүүлэхийг хичээлээ.

Түлхүүр үгс:

Солонгосын хойг, Д.Трамп, АНУ-ын шинэ бодлого, стратеги, ашиг сонирхол

¹ ШУА-ийн ОУХХ-гийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант

Орчин үеийн олон улсын харилцааны загвар

Миний төсөөлж буйгаар Modern paradigm of International relations буюу Орчин үеийн олон улсын харилцааны шинэ загвар дараах байдалтай байж болох юм. Үүнд:


National Interest	Army, strategy	Hard policy	Smart Policy
National Security	Diplomatic	Soft policy	
	Economy	Protectionism	

Орчин үед аливаа улс үндэстний эрх ашиг, аюулгүй байдлыг хангаж байх 4-н арга байж болох юм. Нэгдүгээрт: Цэрэг, стратеги. Хоёрдугаарт: Дипломат. Гуравдугаарт: Эдийн засгийн. Дөрөвдүгээрт: Мэдээлэл. Дээрх 4-н аргыг хэрэглэхэд мөн дагалдсан 4-н чухал бодлого байх ёстой. Цэрэг стратегийн аргыг Хатуу хүчний бодлогоор, Дипломат аргыг зөөлөн хүчний бодлогоор, Эдийн засгийн аргыг өөрийн эдийн засгийг хамгаалах бодлогоор, Мэдээллийн аргыг цахим, дижитал бодлогоор хэрэгжүүлж болно. Дээрх дөрвөн аргаар, уялдах дөрвөн бодлогоо зөв хэрэгжүүлэх аваас Монгол Улсын эрх ашиг, аюулгүй байдлыг хангаж чадах гадаад харилцааны бодлого нь жинхэнэ ухаалаг болох боломжтой юм. Энэ удаагийн өгүүлэлдээ дээрх загварын дагуу Солонгосын хойг дахь АНУ-ын гадаад бодлогод үнэлэлт дүгнэлт өгөхийг хичээлээ.

1. Солонгосын хойгийн асуудлаарх Б.Обамагийн засаг захиргааны баримталсан бодлого, стратеги

Солонгосын хойгийн тогтвортой байдал нь ЗХА-ийн бүс нутгийг энх тайван, цэцэглэл хөгжлийн хамтын талбар болгоход чухал ач холбогдолтой билээ. Иймээс Вашингтон-Токио-Сөүлийн цэрэг-стратегийн гурвалсан холбоо буюу тэнхлэг хэмээх нэр томъёог бүр

1970-80-аад оны заагт олон улсын харилцааны үг хэллэгт бодлогын шинжтэйгээр оруулж иржээ. Энэ үеийн АНУ-ын засаг, захиргаанаас явуулж байсан стратегийн бодлого нь энэ сав нутагт коммунизмын



Мөн энэ арван жилд АНУ, Хятадын хооронд харилцан ойлголцлыг бэхжүүлэх, Солонгосын хойгийн асуудлаар БНХАУ-ын зуучлах оролцоог нэмэгдүүлэх хүчин чармайлтаа үргэлжлүүлсээр байна. Энэ үүднээс бүс нутгийн тогтвортой байдал ба Солонгосын

хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгох, БНСУ, Японы аюулгүй байдлыг хангах оролдлого нь АНУ-ын тус бүс нутаг дахь амин чухал стратегийн зорилт болох тухай тус улсын эрдэмтэд² олонтаа бичсэн байдаг.

АНУ-ын хувьд Солонгосын хойгт Солонгос үндэстний нэгдсэн улс байгуулагдах үйл явцыг эн тэргүүний зорилт болгон тавьдаггүй ч энэ үйл явц БНСУ-д тулгуурлан өрнөх аваас дэмжих хандлагатай байдаг.³ Гэвч БНСУ-ын эрдэмтэдийн үзэж буйгаар шууд нэгдэхэд хүндрэл бэрхшээл их байгааг тоочхын сацуу энэ үйл явц удаан үргэлжлэх нь дамжиггүй гэсэн байр суурьтай ханддаг.

АНУ-ын Батлан хамгаалах сайд Чак Хэйгель Азийн аюулгүй байдлын дээд хэмжээний “Шангри-лагийн хэлэлцээ-2013” уулзалт дээр хэлсэн үгэндээ “... БНСУ-тай 2015 онд Стратегийн холбоотон болж, 2030 онд илүү глобал түвшний холбоотон болохоор бид ярилцаж байна” гээд 2020 онд цэргийн хүчнийхээ 60 хувийг зөвхөн Ази, Номхон далайн бүс нутагт байрлуулах шийдвэр гарсан тухай мэдэгдэж байсан юм.⁴ Гэвч Барак Обамагийн засаг захиргаанаас Умард Солонгосын талаар явуулж ирсэн “Хүлээцтэй байх стратеги” (Strategic patience) бодлогыг Умард Солонгост цөмийн зэвсгээ хөгжүүлэх боломжийг олгож байна хэмээн шүүмжлэх явдал сүүлийн жилүүдэд хүчтэй газар авч байсан юм. Учир нь Умард Солонгосын 4, 5 дахь цөмийн туршилтын дараа Барак Обамагийн засаг захиргааны баримталж байсан бодлого буруу болох нь нотлогдсон талаар АНУ-ын Конгресийн хуралд хэлэлцүүлсэн удаатай.⁵ Тиймээс сонгуульд хэн ялахаас эс хамаарч уламжлалт бодлогод зарим нэг өөрчлөлт гарах болов уу гэж таамаглаж буй судлаачид байна.

Харин БНХАУ-ын хувьд олон улсын өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу сүүлийн жилүүдэд Умард Солонгосын цөмийн хөтөлбөрт хэлбэрийн төдий хатуу хандаж байгаа ч үндсэн эрх ашгийн хувьд Солонгосын нэгдлийн асуудал нь дээрхийн адил БНСУ-д тулгуурлан

2 Charles L. Pritchard, John H. Tilelli, Scott A. Snyder, U.S. Policy Toward the Korean Peninsula, Independent Task Force Report No. 64, New York, 2010, pp.

3 Б.Лхагваа, “Солонгосын хойгийн асуудалд хандах Монгол улсын байр суурь, ЗХА-ийн олон талт хамтын ажиллагаанд хамрагдах чиглэлийн тухай судалгааны зөвлөмж”, Стратегийн судалгаа, Улаанбаатар, 2(2013), 14-15 дугаар тал.

4 Чак Хэйгель, “Бүс нутгийн аюулгүй байдлын талаарх АНУ-ын хандлага”, Азийн аюулгүй байдлын дээд хэмжээний “Шангри-лагийн хэлэлцээ-2013” уулзалт дээр хэлсэн үг, Орчуулсан Л.Бямбаханд, Стратегийн судалгаа, Улаанбаатар, 2(2013), 112 дугаар тал.

5 Ж.Энхсайхан, “Умард Солонгосын цөмийн хөтөлбөр, цаашдын хандлага нөлөө”, Солонгос судлал (Mongolian Journal of Korean Studies), Улаанбаатар, 1(2016), 171 дүгээр тал.

явагдсан нөхцөлд БНХАУ-ын тус хойг дахь байр суурийг сулруулах болно гэж үздэг байна.⁶ Эндээс үзэхэд өнөөдрийн ЗХА-ийн бүсийн энхийн дэг журамд нэг хэсэгтээ АНУ, БНХАУ хоёр голлох үүрэг гүйцэтгэх нь маш тодорхой болж байна. Энэ байдал нь Солонгосын хойгийн асуудлаар АНУ, Хятад хоёрыг хамтран ажиллангаа өрсөлдөхөөс өөр аргагүй байдалд хүргэж байгаа юм. Өнөөдөр тус хойгийн асуудлаар АНУ “Pivot to Asia” (Ази дахь байр сууриа нэмэгдүүлэх), “Rebalancing” (Дахин тэнцвэржүүлэх) стратегиар, БНХАУ “New model of major country relationship” (Их гүрнүүдтэй харилцах шинэ загвар) бодлогоор эрх ашиг нь илэрч байгаа тухай эрдэмтэд бичжээ.⁷ Учир нь 2001 оны 9 дүгээр сарын 11-ний террорист халдлагын дараагаар Вашингтон Ойрх Дорнод руу чиглэсэн цэрэг-улс төрийн бодлогоо ихээхэн идэвхжүүлсэн бол Ерөнхийлөгч Б.Обама 2011 оны эцсээр Ази, Номхон далайн бүс нутагт АНУ-ын үүрэг, нөлөөг нэмэгдүүлэх “Дахин тэнцвэржүүлэх бодлого” (US rebalancing policy towards Asia-Pacific)-оо хэрэгжүүлж эхэлсэн.⁸ Стратегийн хүндийн төв ийнхүү өөрчлөгдсөнөөр АНУ-ын Ази, Номхон далай дахь оролцоо 50:50 болж, улмаар 2020 онд АНУ-ын тэнгисийн цэргийн хүчийг 60:40 харьцаатай болгон нэмэгдүүлэн өөрчлөн байрлуулахаа мэдэгдэж байсан нь⁹ тус бүс нутагт ихээхэн ач холбогдол өгдөг уламжлалт бодлогыг Б.Обамагийн засаг захиргаа эргэн сэргээж байгаагаа илэрхийлсэн алхам болсон юм.

БНХАУ-ын зарим судлаачдын үзэж байгаагаар АНУ-ын “Дахин тэнцвэржүүлэх бодлого” (US rebalancing policy towards Asia-Pacific) нь Ази, Номхон далайн бүс нутаг дахь тэргүүлэх байр сууриа хадгалах, улмаар уг бүс нутагт улс төр, эдийн засаг, батлан хамгаалах нөлөө нь улам бүр тогтвортой нэмэгдэж буй БНХАУ-ын байр суурийг сулруулахад голлон чиглэгдсэн гэж үзэх тал байгаа боловч эцсийн дүнд АНУ болон БНХАУ нь бүс нутаг дахь сөргөлдөгч дайснууд гэхээсээ бүс нутгийн энхтайван, тогтвортой байдал, хөгжил цэцэглэлийн төлөө их гүрнүүдийн шинэ хэлбэрийн харилцааг бий болгохоор чармайж

6 Мөн тэнд

7 Б.Лхагваа, “Зүүн хойд Азийн цэцэглэл хөгжил: Монгол улс, БНСУ-ын хамтын ажиллагаа, үүрэг роль”, Солонгос судлал (Mongolian Journal of Korean Studies), Улаанбаатар, 1(2016), 159 дүгээр тал.

8 Л.Бямбаханд, “АНУ-ын “Дахин тэнцвэржүүлэх бодлого”, Орос, Хятадын хандлага”, Стратегийн судалгаа, Улаанбаатар, 2(2013), 25 дугаар тал.

9 АНУ-ын Батлан хамгаалахын сайд Леон Паннетагийн Азийн аюулгүй байдлын XI дээд хэмжээний уулзалтад хэлсэн үг, 2002.06.02.

байгаа¹⁰ гэдэг талаас нь асуудалд хандаж буйгаа бүтээлдээ илэрхийлж байв.

Тодорхой асуудлаар харилцан ойлголцолд хүрэх эрмэлзэл хоёр их гүрний хэн хэнд нь байгаа ч итгэлцлийн түвшин харьцангуй доогуур хэмжээнд байсаар байна. Түүнчлэн үзэл санаа, үнэт зүйлд хандах нийгмийн сэтгэлгээ, улс төрийн тогтолцоо, үл итгэлцэл зэрэг¹¹ нь олон улсын дэг журам тогтоох чиглэлд хойшид нэмэлт шинэ зөрчил үүсгэхийг үгүйсгэх аргагүй юм.

Обамагийн засаг захиргааны Солонгосын хойгийн асуудлаарх ашиг сонирхол нь хориг арга хэмжээ, урамшуулалыг хослуулах замаар Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгох, Умард Солонгос дахь хүний эрхийн асуудлаар тогтвортой улс төрийн шахалт, уриалгыг нэмэгдүүлэхэд анхаарч ирлээ. Энэ хүчин чармайлтад БНХАУ-ын оролцоо амин чухал болж байна гэдгийг АНУ-ын эрдэмтэд бүтээлдээ олонтаа тэмдэглэснийг дээр дурдсан билээ.¹²



БНХАУ дахь ГШХО-ын дийлэнх хувийг БНХАУ эзэлж байна. Мөн хөгжлийн тусламж, дэмжлэгийн зонхилох хувийг ч БНХАУ үзүүлж байгаа юм. Сүүлийн 10 жилд БНХАУ дахь ГШХО болон

10 Ван Вэнфен, “Ази, Номхон далайн бүс нутагт эргэн ирэх АНУ-ын стратеги, Хятадын байр суурь”, Орос, Хятадын хандлага”, Стратегийн судалгаа, Улаанбаатар, 2(2013), 86 дугаар тал.
11 East Asian Strategic Review-2016, The National Institute for Defense Studies, Japan, 2016, pp.316-321.
12 Charles L. Pritchard, John H. Tilelli, Scott A. Snyder, U.S. Policy Toward the Korean Peninsula, Independent Task Force Report No. 64, New York, 2010, pp.8

Хөгжлийн буцалтгүй тусламжийн хэмжээ 4 жилийн хугацаатайгаар огцом өсөж, буурсан үзүүлэлтэй байсан нь сонирхол татаж байна.¹³ 2014 онд БНАСАУ-аас Хятад руу хийсэн экспорт 2.5 хувиар буурч 2.84 тэрбум доллар, харин импорт мөн 10.7 хувиар өсч 4.02 тэрбум долларт хүрсэн байна. БНАСАУ-ын гадаад худалданы нийт хэмжээ мөн онд 7.61 тэрбум ам.доллар байснаас зөвхөн БНХАУ-тай 6.88 тэрбум ам.доллар буюу тус улсын гадаад худалдааны 90.1 хувь (2013 онд энэ харьцаа 89.1 хувь байсан) дангаар ноогдож байжээ. Эндээс үзэхэд Умард Солонгосын эдийн засаг БНХАУ-аас шууд хамааралтай нь харагдаж байна.¹⁴

Иймээс БНАСАУ-ын хувьд бүс нутаг дахь хамгийн чухал стратегийн түнш орон бол БНХАУ болж байна. БНХАУ нь БНАСАУ-ын хувьд:

1. Улс төр, аюулгүй байдлын түүхэн уламжлалт харилцаатай. Өнөөдөр ч харилцан туслалцах (Батлан хамгаалах, эдийн засаг, соёл гэх мэт) гэрээтэй цөөн орнуудын нэг.
2. Худалдаа, эдийн засгийн гол харилцаатай орон. Умард Солонгосын экспорт, импорт, ГШХО, буцалтгүй тусламжийн бараг бүх хувь хэмжээ БНХАУ-д ноогдож байна.¹⁵
3. Умард Солонгосын компани, аж ахуйн нэгжүүд хамгийн олноор үйл ажиллагаа явуулж, умардын иргэд хамгийн ихээр цагаачилдаг, ажиллаж амьдардаг орон бол мөн БНХАУ юм.

Иймээс Умард Солонгосын цөмийн хөтөлбөр, Солонгосын хойгийн аюулгүй байдлын асуудалд БНХАУ-ын үзүүлэх нөлөө асар их болох нь хэн бүхэнд тодорхой байна.

1. Дональд Трамп ба Солонгосын хойгийн асуудлаарх АНУ-ын шинэ бодлого, стратеги, ашиг сонирхол

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажил саяхан өндөрлөсөн тул АНУ-аас Умард Солонгостой харилцах бодлогод 2017 оны хавар хүртэл зарчмын ямар нэгэн өөрчлөлт гарахгүй (хэрэв Умард Солонгосын талаас илт өдөөн хатгасан арга хэмжээ авахгүй бол) гэж үзэж байгаа судлаачид цөөнгүй байна.

13 <http://databank.worldbank.org/data/reports.aspx?source=2&country=PRK>

14 East Asian Strategic Review-2016, The National Institute for Defense Studies, Japan, 2016, pp.90.

15 East Asian Strategic Review-2016, The National Institute for Defense Studies, Japan, 2016, pp.316-321.

Гэвч 2016 оны 11 дүгээр 8-нд явагдсан АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн дэлхий нийтийг тэр дундаа Солонгосын хойгт зэрэгцэн орших БНСУ, БНАСАУ-ын хувьд, цаашилбал Япон улсын хувьд хүсэж тооцож байсан үр дүнг авчраагүй нь тухайн үед олон нийтийн сүлжээ, мэдээллийн хэрэгслүүдийн агуулгаас тодорхой харагдаж байна. Учир нь Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр удаа дараа олон нийтийг гайхшруулсан, гэнэтийн, зарим үед дэндүү хариуцлагагүй гэмээр мэдэгдэл хийж “бэлэг” барьдаг өвөрмөц имиждэй болоод байгаа ноён Д.Трампыг Нэгдсэн улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараа БНСУ-ын Аюулгүйн зөвлөлийн хурал яаралтай хуралдсан нь санамсаргүй хэрэг огт биш юм.¹⁶

Д.Трампыг Солонгосын хойгийн талаар, тэр дундаа Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийн асуудлаар ямар зарчмын байр суурь баримтлах вэ гэдэг асуулт өнөөдөр олон нийтийн дунд таавар хэвээр байна.

Д.Трамп ирээдүйд юу хийхийг хэн ч урьдчилан тааварлаж чадахгүй ч түүний хэлж байсан үг, мэдэгдлүүдээс түүний кабинетийн ирээдүйн бодлого, стратегийн ерөнхий хандлагыг төсөөлөн зураглаж болох юм.

АНУ-ын шинэ Ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа Д.Трамп энэ онд АНУ-ын Fox телевизийн “Fox&Friends” нэвтрүүлэгч өгсөн ярилцлагадаа: “БНХАУ нь Умард Солонгосын асуудлыг зохицуулах ёстой. Хэрэв чадахгүй бол бид Хятадтай худалдаа хийхэд хүндрэл үүсэх болно” хэмээн ярьсан байдаг.¹⁷ Д.Трампын энэ мэдэгдлээр бүх бодлогыг дүгнэхэд хангалтгүй ч тэрээр өмнө хэвшин тогтсон АНУ-аас Солонгосын хойгийн асуудлаар Хятадтай ойлголцох, хүлээцтэй хандахыг чухалчилж ирсэн уламжлалт хандлагыг чангатгаж мэдэхээр байна.

Д.Трампын Солонгосын хойгийн асуудлаар баримтлах бодлогын талаар тус хойгийн аюулгүй байдлын судалгаагаар мэргэжсэн 12 гол эрдэмтний урьдчилсан дүгнэлт бүхий судалгааг гаргасан байна. Энэхүү судалгаагаар дээрх 12 эрдэмтний 10 эрдэмтэн¹⁸ нь Д.Трампыг

¹⁶ http://www.nytimes.com/2016/11/09/world/europe/global-reaction-us-presidential-election-donald-trump.html?_r=0

¹⁷ <http://www.businessinsider.com/hillary-clinton-and-donald-trump-platform-on-foreign-policy-issues-2016-9>

¹⁸ 트럼프 행정부 대북정책은? 미 한반도 전문가 14명에게 묻다 원문보기: <http://www.hani.co.kr/arti/international/america/770220.html>

Солонгосын хойгийн асуудлаар хатуу бодлого байр суурь баримтална гэж үзсэнээс тодорхой харагдаж байна.

Дээрх эрдэмтдийн үзэж буйгаар Д.Трампын засаг захиргаа Солонгосын хойгийн асуудлаар

1. Эхэн үе (6 сараас- 1 жил)-дээ Хатуу байр суурь баримтална.
2. Дунд үе (1 жилээс хойш)-дээ Хэлэлцээр хийхийг чухалчилна.
3. Сүүл үе (2 жилээс хойш)-дээ Уламжлалт бодлого үргэлжилнэ гэсэн дүгнэлт гаргасан байна.¹⁹

Сүүл үед уламжлалт бодлого хэвээр үргэлжилнэ гэж дээрх эрдэмтдийн таамаглалд туссан байгаа нь бас үндэслэлтэй байна. Учир нь зарим судлаачдын үзэж байгаагаар Д.Трамп сонгуулийнхаа кампанит ажлынхаа үеэр олон зүйл ярьж байсан ч түүнд улс төрийн туршлага бага. Тиймээс АНУ-ын Батлан хамгаалахын сайд хэн болох нь дурдан буй асуудлаар ихээхэн нөлөө үзүүлнэ. Учир нь түүний зөвлөхүүд болон кабинетийн гишүүдийн үзэл санаагаар түүний хэлэх үг хэрхэн өөрчлөгдөхийг өнөөдөр хэн ч мэдэхгүй байна. Иймээс Д.Трампын дэргэд ажиллах улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын асуудлаар мэргэжсэн зөвлөх, шинжээч эрхмүүдийн үзүүлэх нөлөөллийг энд марталгүй тооцох нь чухал болж байна.

Д.Трамп гадаад бодлогодоо баримтлах хатуу чиг шугамаа үгэндээ нэгэнтээ онцлон дурдсан бөгөөд “Б.Обама Ерөнхийлөгч Умард Солонгосын өсөн нэмэгдэж буй цөмийн аюулыг зүгээр хараад сууж байна. Мөн Америкийн эдийн засаг дахь БНХАУ-ын дайралтыг хүлээн зөвшөөрсөн. Тиймээс бид нэг бол худалдааг хязгаарлана, үгүй бол Умард Солонгост БНХАУ өөрийн нөлөөг хэрэгжүүлэх шаардлагатай”²⁰ хэмээн мэдэгдсэн юм.

Иймээс Д.Трампын гадаад бодлого дахь гол анхаарал нь яах аргагүй БНХАУ болж байна. Гэвч энд тэмдэглэхэд, Солонгосын хойгийн асуудлаар Хятад улсыг онцлон анхаарч байгаа үзэл санаа нь дан ганц Д.Трампын гаргаж дэвшүүлсэн баримтлал биш бөгөөд АНУ-ын тэргүүлэх эрдэмтэд олон жилийн өмнөөс ийм санаачлагыг байнга

19 페이스북 트위터 공유 스크 프린트 크게 작게 <한겨레> 미국 한반도 전문가들 설문조사 “단기적으로 대북제재 강화” 중·장기적 전망은 엇갈려 원문보기:
<http://www.hani.co.kr/arti/international/america/770220.html#csidxd4cdaecf4c6f50b94c81dc55b2dc500>
20 <https://www.donaldjtrump.com/press-releases/donald-j.-trump-foreign-policy-speech> - APRIL 27, 2016

дэвшүүлж бичсээр ирсэн юм.²¹

Мөн тэрбээр 2016 оны 3 дугаар сард Нью Йорк Таймс сонин хэлсэн үгэндээ: “Япон улс өөрийн цөмийн зэвсгийн чадамжийг нэмэгдүүлж, Умард Солонгосын түрэмгийллийн эсрэг хариу арга хэмжээ авахыг Ерөнхийлөгч дэмжих хэрэгтэй” хэмээн мэдэгдээд эдгээр харилцаанд санхүүгийн хандиваа нэмэгдүүлэхгүй бол Япон, БНСУ-аас Нэгдсэн улсын цэргийг дуртайяа гаргана” гэж мэдэгдсэн нь АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнгийн дараах тус улсын Ази дахь гол холбоотон болох БНСУ, Японы эрх баригчдын сэтгэлийг зовоосон гол мессеж болоод байгаа юм.

Иймээс Д. Трампын Азийн тухай баримтлах бодлого нь АНУ-ын өмнөх засаг захиргаанаас зарчмын хувьд эрс ялгагдахаар байх магадлалтай бөгөөд энэ нь түүний сонгуулийн үеэр оноо цуглуулах зорилгоор хариуцлагагүй мэдэгдсэн үг гэж үзэх боломжгүй болж байна. Учир нь тэрбээр бүр 2000 онд “Хэрэв Умард Солонгос цөмийн зэвсгийн технологгоо үргэлжлүүлэн хөгжүүлэх аваас бид түрүүлж цохилт өгнө. Нэг бол цөмийн зэвсгээс татгалз, эс бөгөөс 1986 онд Муммар Кадафид Роналд Рейганы²² өгсөн шиг хариу арга хэмжээ авах болно” хэмээн хэлж байсан удаатай.

Харин Умард Солонгосын талаас одоогоор АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнг анхааралтай ажиглаж байгаа бололтой. Д.Трампын Солонгосын хойгийн асуудлаарх удаа дараагийн мэдэгдлийн дараа ямар нэг албан ёсны байр сууриа илэрхийлээгүй байгаа ч АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулиас өмнө НҮБ дахь БНАСАУ-ын Хүмүүнлэгийн болон хүний эрхийн асуудал хариуцсан захирал Ким Ён Хо НҮБ-ын Ерөнхий Ассемблейн хуралдааны дараа сурвалжлагчийн асуултад харилуахдаа: “АНУ-ын Ерөнхийлөгч хэн болох нь бидэнд хамаагүй. Үндсэн асуудал нь АНУ-ын улс төр бус тэд бидэнд хандсан дайсагнасан бодлогоо татаж авах ёстойд байгаа юм”²³ хэмээн мэдэгдсэн.

ХБНГУ-ын бодлогын судалгааны SWP (Stiftung Wissenschaft und Politik)-ын зарим судлаачдын бичиж байгаагаар Д.Трампын гадаад бодлого нь сонгуулийн кампанит ажлын хүрээнд яригдаж байсан

21 Mike Mullen, Sam Nunn and Adam Mount, A Sharper Choice on North Korea, Independent Task Force Report No. 74, New York, 2016.

22 <http://www.cfr.org/campaign2016/>

23 <http://www.businessinsider.com/north-korea-we-do-not-care-who-is-president-of-the-united-states-2016-11>

“Хүчирхэг Америкийг эргүүлэн авчрах” бодлогын хүрээнд гадаад асуудлаас илүү дотооддоо ашигтай байх нөхцлийг гол болгон олон улсын зарим хүлээсэн үүргээсээ буцаж магадгүй байгаа²⁴ тухай бичиж байсан нь ТРР(Номхон далай дамнасан түншлэл)-ээс гарах түүний мэдэгдлийн дараа үндсэндээ нотлож байна. Учир нь Д.Трамп Засгийн газрын шинжээчдийн үгийг дагавал Б.Обамагийн бодлогоос ялгарах зүйлгүй болно. Тиймээс Д.Трамп шинжээчдийн үгийг нэг их дагахгүй болов уу гэх таамаглал хүчтэй яригдсаар байна.

Д.Трампыг гайхшруулсан мэдэгдлүүдээ хийж байх завсар тус нутгийн ард түмний үзэл бодол ч ихээхэн өөрчлөгдсөн байна. Тухайлбал, БНСУ-ын олон нийтийн дунд 2016 онд явуулсан судалгааны үр дүнгээс харахад ард түмний талаас илүү хувь нь цөмийн зэвсэгтэй болохыг хүлээн зөвшөөрч эхэлж байгаа ажээ. Өмнө нь ард түмний дунд ийм судалгааг явуулахад цөмийн зэвсэгтэй болох тухай яриа байх боломжгүй зүйл гэсэн дүн байнга гардаг байсан бол одоо бага ч гэсэн боломж гарч ирлээ хэмээн БНСУ-ын ихэнх экспертүүд ярьж байна.²⁵

Одоогоор БНСУ-ын зарим шинжээч олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сонирхолтой дүгнэлт гаргалгаануудыг бичиж нийтэлсээр байна. Түүний заримаас нь сонирхуулахад:

“... Д.Трамп Умард Солонгостой хэлэлцээрийн ширээний ард суухаас айхгүй. Б.Обамагийн хувьд Умард Солонгосыг цөмийн хөтөлбөрөө цуцалсан нөхцөлд л хэлэлцээрийн ширээний ард суух боломжтой гэсэн байр суурьтай байлаа. Харин Умард Солонгос бол хэлэлцээр хийхийг зөвшөөрч байна. Иймээс Д.Трампын засаг захиргааны үед хэлэлцээрийн ширээний ард суух өндөр магадлалтай. Д.Трамп олон жилийн туршид хийж байсан бүх хэлэлцээртээ ялсаар ирсэн тул Умард Солонгостой хэлэлцээр хийхдээ ч мөн ялах магадлалтай. Д.Трамп сонгуулийнхаа кампанит ажлын үеэр АНУ-ын гадаад бодлогын асуудлаар ярихдаа шаардлагатай бол хүч хэрэглэнэ гэж мэдэгдэж байсан бөгөөд уг мэдэгдэл нь үнэн бол дэлхийд ихээхэн аюул учруулах болно. Д.Трампын хүч хэрэглэж болох газар хаана вэ гээд хайж үзвэл гарцаа байхгүй Умард Солонгос болж байна. Хэрвээ Д.Трамп хэлэлцээр амжилтгүй болбол хүч хэрэглэх магадлалтай. Ким

24 Volker Perthes, “Präsident Trump und die internationalen Beziehungen”, SWP (Stiftung Wissenschaft und Politik), Berlin, 14.11.2016.

25 <https://www.nknews.org/2016/11/president-trump-what-does-this-mean-for-north-korea/>

Жон Ун АНУ-ын хэлсний дагуу асуудлыг шийдвэрлэхгүй бол түүний дэглэм унах магадлалтай. Д.Трампа бол маш бардам хүн. Түүнээс юу ч гарч магадгүй ба тэр ялагдах дургүй. Тиймээс Умард Солонгосын залуу удирдагч өөрийн дэглэм үү? өөрийн амь нас уу? гэдэг хэцүүхэн сонголттой тулгарч болно”²⁶ хэмээн бичсэн байна.

БНСУ-ын эх сурвалжуудаас үзвэл Умард Солонгост Д.Трампыг Ерөнхийлөгчөөр сонгогдсон тухай улс даяар нууцалж байгаа гэх мэдээлэл байгаа нь түүнийг сонгогдсонд тус улс сандарч байж болзошгүйг харуулж байгаа юм. Учир нь БНСУ, БНАСАУ-ын аль аль нь Хиллари Клинтоньг дараагийн Ерөнхийлөгчөөр сонгогдоно хэмээн бүх бодлого, стратегиа боловсруулж төлөвлөж байсан нь тодорхой байна. Түүнчлэн БНХАУ-д Д.Трампыг Ерөнхийлөгчөөр сонгогдвол баримтлах бодлогын талаар бэлэн сценари байхгүй байгаа бололтой.²⁷

4. Дүгнэлт, санал

АНУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн үр дүнд Д.Трампа сонгогдон гарч ирсэнээр Солонгосын хойгийн төдийгүй Ази, Номхон далайн бүс нутагт АНУ-ын явуулж ирсэн уламжлалт бодлогод ихээхэн өөрчлөлт гарах нь нэгэнт тодорхой боллоо. Д.Трампа АНУ-ыг Номхон далайг дамнасан хамтын ажиллагааны хэлцэл ТРП(Номхон далайг дамнасан түншлэл)-ээс гаргах хүсэлтэй байгаа тухайгаа ч илэрхийлж, үүний оронд харин АНУ-д аж үйлдвэрлэл, ажлын байруудыг буцаан авчрахын тулд хоёр талт гэрээ хэлцлүүдийг ихээр хийх бодолтой байгаагаа илэрхийлсэн. Цаашид АНУ-ын Солонгосын хойгийн талаар баримталж ирсэн уламжлалт бодлого өөрчлөгдөх магадлал өндөр байна. Энэ тохиолдолд уг бүс нутгаар тогтохгүй Зүүн хойд Азийн орнуудын тогтвортой байдалд энэ нь ихээхэн нөлөөлөх нь тодорхой болж байна. Иймээс эл асуудлаар үйл явцын хэтийн төлөвийг урьдчилан тооцсон олон хувилбарт судалгааг ул суурьтай үргэлжлүүлэн хийх шаардлагатай болж байна.

Умард Солонгос сүүлийн жилүүдэд цөмийн зэвсгийн сангаа нэмэгдүүлэх, илүү дэвшилтэт пуужингийн технологийг эзэмших

26 트럼프의 대북정책은... http://www.rfa.org/korean/weekly_program/joosungha/co-sh-11112016084500.html

27 <http://www.swp-berlin.org/publikationen/kurz-gesagt/nach-der-us-wahl-unsicherheit-in-china-schock-in-japan.html> Volker Stanzel, “Nach den US-Wahlen: Unsicherheit in China, Schock in Japan”, SWP (Stiftung Wissenschaft und Politik), Berlin, 10.11.2016.

талаарх ихээхэн хөөцөлдөж байгаа, террорист бүлэглэлд цөмийн зэвсэг болон материалыг дамжуулж болзошгүй байгаа зэрэг асуудал нь АНУ, түүний холбоотнуудад ихээхэн аюулыг буй болгож байна. Гэвч Умард Солонгосыг цөмийн хөтөлбөрийн зохицуулах 6 талт хэлэлцээр ахиц дэвшилээр дутмаг байсаар 2017 онтой золгох төлөвтэй байна. Бид эндээс дурдан буй асуудлаар дараах дүгнэлт, саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. АНУ болон түүний холбоотнууд Солонгосын хойгийн асуудлаар нийтлэг ашиг сонирхлынхоо дагуу хамтран ажиллах нь хамгийн зөв сонголт байх болно гэдэгт БНХАУ-ыг итгүүлж явдал нь ойрын жилүүд дэх АНУ-аас тус бүс нутагт явуулах бодлогод чухал нөлөөлөл үзүүлэх бололтой.²⁸
2. Вашингтоны зүгээс бүс нутаг дахь түүний холбоотнууд болох Япон, БНСУ-тай нягт харилцаатай байж Умард Солонгосын асуудлыг шийдвэрлэх боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрч байна.
3. БНХАУ-ын зүгээс Д.Трампын мэдэгдэлд үндэслэн Умард Солонгосын асуудлаар шинэ тоглолт хийн бүс нутагт байр сууриа улам бэхжүүлэх магадлалтай байна.
4. АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа Д.Трамп нь Солонгосын хойгийн асуудал, тэр дундаа Умард Солонгосын асуудлаар өмнөх Ерөнхийлөгч Б.Обамагийн “Хүлээцтэй байх стратеги” стратегийг баримтлахгүй байх магадлал өндөр байна. Олон улсын шинжээчдийн үзэж байгаагаар Д.Трамп Умар Солонгостой ямар нэгэн нөхцөл тавихгүйгээр хэлэлцээрийн ширээний ард суух магадлал өндөр байгаа ч, энэ оролдлого нь бүтэлгүйтвэл хүч хэрэглэж “хатуу байр суурь” баримталж асуудлыг шийдвэрлэх магадлалтай байна.
5. БНСУ-ын хувьд Солонгосын хойгийн аюулгүй байдлыг хамгаалах АНУ-ын оролцоог хэвээр хадгалахын тулд нэмэлт төлбөр төлөх Д.Трампын болзлыг хүлээн авах магадлалтай байна. Ингэсэн нөхцөлд БНСУ-аас АНУ-д нэмэлт нөхцөлд шаардлага тавих хувилбарыг сонгон авч уламжлалт цэрэг-батлан

28 Mike Mullen, Sam Nunn and Adam Mount, A Sharper Choice on North Korea, Independent Task Force Report No. 74, New York, 2016, pp.

хамгаалах, аюулгүй байдлын баталгаагаа хэвээр үргэлжлүүлэх чиг баримтлалыг сонгон авах болов уу гэж үзэж байна.

Эхний хэсэгт харуулсан загварын дагуу дараах дүгнэлтийг хийж болох юм.

Хатуу бодлогын АНУ-ын армийн хүчийг нэмсэн, БНСУ-аас төлбөрөө нэмэхийг шаардсан зэрэг хатуу бодлогыг баримталж эхэлж байна.

Зөөлөн бодлогын хувьд нөхцөл тавилгүй БНАСАУ-тай ширээний ард суух, хэлэлцээр хийхээр тохирохыг уриалав.

Хамгаалах бодлогын хувьд Худалдааны алдагдалыг арилгах, ажлын байр нэмэгдүүлэх тал дээр анхаарал түлхүү анхаарав.

Мэдээллийн бодлогын хувьд Мэдээллийн аюулгүй байдлаа хадгалах, Ардчилалыг аль болох Хойд Солонгост мэдүүлэх, мэдээллийн хэрэгсэл болон бусад сувгаар түгээх зэрэг арга хэмжээг авч байна.

Энэ загварын дагуу харвал Барак Обамагийн засгийн газраас илүү ухаалаг бодлогыг Доналд Трампын засгийн газар хэрэгжүүлэх төлөвтэй байгаа боловч Өмнөд Солонгос, Япон, Хятад зэрэг орнуудад шахалт үзүүлж байгаа нь өөрийн нэгэнт тогтсон орон зайгаа алдахад хүргэх эрсдэлтэй байна.

5. Ном зүй, цахим эх сурвалж:

1. Mike Mullen, Sam Nunn and Adam Mount, A Sharper Choice on North Korea, Independent Task Force Report No. 74, New York, 2016.
2. Charles L. Pritchard, John H. Tilelli, Scott A. Snyder, U.S. Policy Toward the Korean Peninsula, Independent Task Force Report No. 64, New York, 2010.
3. East Asian Strategic Review-2016, The National Institute for Defense Studies, Japan, 2016, pp.316-321.
4. Б.Лхагваа, “Солонгосын хойгийн асуудалд хандах Монгол улсын байр суурь, ЗХА-ийн олон талт хамтын ажиллагаанд хамрагдах чиглэлийн тухай судалгааны зөвлөмж”, Стратегийн судалгаа, Улаанбаатар, 2(2013), 14-15 дугаар тал.
5. Чак Хэйгель, “Бүс нутгийн аюулгүй байдлын талаарх АНУ-ын хандлага”, Азийн аюулгүй байдлын дээд хэмжээний “Шангри-лагийн хэлэлцээ-2013” уулзалт дээр хэлсэн үг, Орчуулсан Л.Бямбаханд, Стратегийн судалгаа,

- Улаанбаатар, 2(2013), 112 дугаар тал.
6. Ж.Энхсайхан, “Умард Солонгосын цөмийн хөтөлбөр, цаашдын хандлага нөлөө”, Солонгос судлал (Mongolian Journal of Korean Studies) , Улаанбаатар, 1(2016), 171 дүгээр тал.
 7. Б.Лхагваа, “Зүүн хойд Азийн цэцэглэл хөгжил: Монгол улс, БНСУ-ын хамтын ажиллагаа, үүрэг роль”, Солонгос судлал (Mongolian Journal of Korean Studies) , Улаанбаатар, 1(2016), 159 дүгээр тал.
 8. Л.Бямбаханд, “АНУ-ын “Дахин тэнцвэржүүлэх бодлого”, Орос, Хятадын хандлага”, Стратегийн судалгаа, Улаанбаатар, 2(2013), 25 дугаар тал.
 9. АНУ-ын Батлан хамгаалахын сайд Леон Паннетагийн Азийн аюулгүй байдлын XI дээд хэмжээний уулзалтад хэлсэн үг, 2002.06.02.
 10. Ван Вэнфен, “Ази, Номхон далайн бүс нутагт эргэн ирэх АНУ-ын стратеги, Хятадын байр суурь”, Орос, Хятадын хандлага”, Стратегийн судалгаа, Улаанбаатар, 2(2013), 86 дугаар тал.
 11. Marco Overhaus/ Lars Brozus, “US -Außenpolitik nach den Wahlen 2016 Gegenständliche Leitbilder der Präsidentschaftsbewerber und innenpolitische Dynamik“, SWP (Stiftung Wissenschaft und Politik), Berlin, 2016.
 12. <http://www.swp-berlin.org/publikationen/kurz-gesagt/nach-der-us-wahl-unsicherheit-in-china-schock-in-japan.html> Volker Stanzel, “Nach den US-Wahlen: Unsicherheit in China, Schock in Japan”, SWP (Stiftung Wissenschaft und Politik), Berlin, 10.11.2016.
 13. <http://www.businessinsider.com/north-korea-we-do-not-care-who-is-president-of-the-united-states-2016-11>
 14. Volker Perthes, “Präsident Trump und die internationalen Beziehungen”, SWP (Stiftung Wissenschaft und Politik), Berlin, 14.11.2016. <http://www.businessinsider.com/hillary-clinton-and-donald-trump-platform-on-foreign-policy-issues-2016-9> 트럼프 행정부 대북정책은? 미 한반도 전문가 14명에게 묻다 원문보기: <http://www.hani.co.kr/arti/international/america/770220.html> <https://www.donaldjtrump.com/press-releases/donald-j.-trump-foreign-policy-speech> - APRIL 27, 2016
 15. <http://www.cfr.org/campaign2016/http://www.businessinsider.com/north-korea-we-do-not-care-who-is-president-of-the-united-states-2016-11> <https://www.nknews.org/2016/11/president-trump-what-does-this-mean-for-north-korea/>
 16. 트럼프의 대북정책은... http://www.rfa.org/korean/weekly_program/joosungha/co-sh-11112016084500.html